

**ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /8-р сарын 6-наас 9-р сарын 3-ны байдлаар, төгрөгөөр/**

№	Барааны нэр, төрөл	VIII/6	VIII/13	VIII/20	VIII/27	IX/03
1	Гурил, I зэрэг, кг	1000	1000	1000	1000	1000
2	Хонины мах, кг/ ястай/	7000	7000	7000	6500	6500
3	Үхрийн мах, кг /ястай/	8500	8500	8500	8500	8500
4	Ямааны мах /ястай /	6000	6000	6000	5500	5500
5	Элсэн чихэр, кг	1600	1600	1600	1600	1600
6	Цагаан будаа, кг	2150	2150	2150	2150	2150
7	Шингэн сүү, л	800	800	800	800	800
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
9	- Бор ноолуур	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
10	Бензин, А-80, 1 литр	1570	1570	1570	1570	1570
11	Бензин, А-92, 1 литр	1690	1690	1690	1690	1690
12	Дизелийн түлш, 1 литр	1790	1790	1790	1790	1790

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2014 оны 8-р сарын 6-наас 2014 оны 9-р сарын 3-ны хооронд “Алтан тариа” ХК 1-р гурил, үхрийн ястай мах, элсэн чихэр, цагаан будаа, шингэн сүү, шатахууны ханш тогтвортой байсан бол хонь, ямааны ястай махны үнэ буурч, ноолуурын арилжаа хийгдээгүй байна.

**Махны үнэ.** 8-р сарын 20-ны өдөр хүртэл хонины ястай мах 1 кг нь 7000 төгрөг байсан бол 8-р сарын 27-ноос 7,1 хувь буюу 500 төгрөгөөр буурч 6500 төгрөг болсон. Үхрийн ястай мах сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой 8500 төгрөгийн ханштай байна. Ямааны ястай мах 8-р сарын 27-оос 5500 төгрөг болж өмнөх 7 хоногийн үнэнээс 8,3 хувиар буурав.

**Гурил, элсэн чихэр, цагаан будаа, шингэн сүү.** Эдгээр бүтээгдэхүүний үнэ сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой байлаа.



